

БАТЛАВ  
ШШГЕГ-ЫН 429 ДҮГЭЭР ХААЛТТАЙ ХОРИХ АНГИ-  
ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЭМНЭЛГИЙН ДАРГА,  
ДЭД ХУРАНДАА... Ж.ЦЭРЭН-ОТГОН

**429 ДҮГЭЭР ХААЛТТАЙ ХОРИХ АНГИ-ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЭМНЭЛЭГ**

Огноо: 2020 оны 01 дүгээр сарын 13

**ШШГЕГ-ЫН 429 ДҮГЭЭР ХААЛТТАЙ ХОРИХ АНГИД ШААРДЛАГАТАЙ  
ТҮЛШ, ШАТАХУУН НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ  
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

**Тендер  
шалгаруулалт  
гэрээний нэр:**

ШШГЕГ-ЫН 429 дүгээр хаалттай хорих ангид шаардлагатай  
түлш, шатахуун

Тендер  
шалгаруулалт  
гэрээний дугаар:

ШШГЕГ 429 Б20/03

УЛААНБААТАР ХОТ  
2020 ОН

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2020 оны 01 дүгээр сарын 13 ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр, дугаар: **“ШШГЕГ-ЫН 429 ДҮГЭЭР ХААЛТТАЙ ХОРИХ АНГИ-ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЭМНЭЛЭГТ ШАТАХУУН НИЙЛҮҮЛЭХ” ШШГЕГ 405 Б20/03**

ШШГЕГ-ЫН 429 дүгээр хаалттай хорих анги- төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **“ШШГЕГ-ЫН 429 дүгээр хаалттай хорих анги- төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт шатахуун нийлүүлэх”** тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Тендерийн материалыг цахим худалдан авах ажиллагааны систем [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (pdf)-ээр илгээнэ. Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 50 000 төгрөгийг [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)-ээр банкны меркантийн системийг ашиглан төлнө.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: **Сүүлийн 1 жил буюу 2018 оны эцсийн санхүүгийн тайланг ирүүлнэ.**
2. Борлуулалтын хэмжээ: **Сүүлийн 1 жил /2018/-ийн борлуулалтын орлогын дундаж нь 31 500 000 /гучин нэгэн сая таван зуун мянга/ төгрөгөөс багагүй байна.**
3. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн дүн: **13 500 000 /арван гурван сая таван зуун мянга/ төгрөгөөс багагүй байна.**
4. Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл ирүүлэх жилийн тоо: **Сүүлийн 1 жил /2018/ он**
5. Тусгай зөвшөөрөл: **Шатахуун импортлох тусгай зөвшөөрөл; Гарал үүслийн гэрчилгээ, түүнтэй дүйцэхүйц баримт бичиг ирүүлнэ.**

Тендерийг 2020 оны 01 дүгээр сарын 21 өдрийн 11 цаг 00 минутаас өмнө цахим системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 21 дүгээр хороо, Таширын ам, 405 дугаар хаалттай хорих ангийн хурлын зааланд 2020 оны 01 дүгээр сарын 21 өдрийн 11 цаг 15 минутад нээнэ.

Гадаадын этгээд оролцох эрхгүй.

Дотоодын давуу эрхийн зөрүү тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичигтэй холбоотой мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 21 дүгээр хороо, Таширын ам,  
429 дүгээр хаалттай хорих анги- төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг Утас : 93044730

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа  
1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт  
2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.  
2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3. Тендерийн иж бүрдэл  
3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:  
(а) Үнийн санал;  
(б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;  
(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;  
(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;  
(е) Харьяа татварын албаны тодорхойлолт  
(ё) Нийгмийн даатгалын хэлтсийн тодорхойлолт  
(ж) Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолт
4. Тогтмол үнэ  
4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд  
5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.  
5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа  
6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх  
7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.  
7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь ТШӨХ-д заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.  
7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл  
8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

**ХОЁРДУГААР БҮЛЭГ**

**ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

Тухайн тендер шалгаруулалтын үр дүнд гүйцэтгэх ажлын талаарх дор дурдсан өгөгдөл нь ТӨӨЗ-ны холбогдох зүйл, заалтад нэмэлт мэдээлэл оруулах, эсхүл өөрчлөх зорилготой. Хэрэв ТӨӨЗ-ны зүйл заалттай зөрчилдвөл энэхүү ТШӨХ-д дурдсан мэдээллийг зөв гэж үзнэ.

<b>ТӨӨЗ-ны холбогдох заалт</b>	<b>А. Ерөнхий зүйл</b>			
<b>ТӨӨЗ 1.1</b>	Захиалагч: <b>ШШГЕГ-ЫН 429 дүгээр хаалттай хорих анги-төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг</b>			
<b>ТӨӨЗ 1.1</b>	Санхүүжилтийн эх үүсвэр нь: <b>Улсын төсөв</b>			
<b>ТӨӨЗ 1.2</b>	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>“Үгүй”</b>			
<b>ТӨӨЗ 1.1 а</b>	Үнийн санал <b>/маягтын дагуу ирүүлнэ /</b>			
<b>ТӨӨЗ 1.1 б</b>	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ: <b>Улсын бүртгэлийн гэрчилгээний эхээс хийсэн хуулбарыг нотариатаар баталгаажуулан ирүүлнэ.</b>			
<b>ТӨӨЗ 1.1 в</b>	Уг ажлыг гүйцэтгэхэд тусгай зөвшөөрөл зайлшгүй шаардлагатай эсэх: <b>“Тийм” Шатахуун импортлох тусгай зөвшөөрөл; Гарал үүслийн гэрчилгээ, түүнтэй дүйцэхүйц баримт бичиг ирүүлнэ.</b>			
<b>ТӨӨЗ 1.1 г</b>	<b>Тендерт оролцогч хуулийн 14 дугаар зүйлийн 14.1 -14.7-д дурдсан нөхцөл үүссэн тухай мэдэгдлийг захиалагчид бичгээр гаргаж ирүүлнэ.</b>			
<b>ТӨӨЗ 1.1 д</b>	Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: <b>Сүүлийн 1 жил буюу 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, дүгнэлтийн хамт ирүүлнэ.</b>			
<b>ТӨӨЗ 1.1 е</b>	Борлуулалтын хэмжээ: <b>Сүүлийн 1 жил /2018/-ийн борлуулалтын орлогын дундаж нь 31 500 0000 /гучин нэгэн сая таван зуун мянга/ төгрөгөөс багагүй байна.</b>			
<b>ТӨӨЗ 1.1 ё</b>	Ижил төстэй бараа гэрээгээр нийлүүлсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: <b>Сүүлийн 1 жил /2018/-ийн аль нэгэнд ядаж нэг удаа 31 500 0000 /гучин нэгэн сая таван зуун мянга/ төгрөгөөс багагүй үнийн дүнтэй шатахуун нийлүүлсэн үндсэн гүйцэтгэгчээр ажилласан туршлагатай байна.</b>			
	<b>№</b>	<b>Гэрээний нэр</b>	<b>Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо барих утас /факс</b>	<b>Төсөвт өртөг</b>
1				<b>Дууссан, эсхүл дуусах хугацаа</b>
	ДҮН			
Дээрх онуудад энэхүү гэрээгээр хийгдэх ажилтай ижил төстэй шатахуун нийлүүлсэн нотлох баримт ирүүлнэ.Үүнд: - Шатахуун нийлүүлсэн гэрээ,				
<b>ТӨӨЗ 1.1 ж</b>	Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн дүн: <b>13 500 000 /арван гурван сая таван зуун мянга/ төгрөгөөс багагүй байна.</b> Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийн аль нэгээр тодорхойлно.			

	-Харилцагч банкин дахь дансны үлдэгдэл -Арилжааны банкны судлагдсан зээлийн авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолт
<b>Тендер ирүүлэх</b>	
ТӨӨЗ 2.1	Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: <b>2020 оны 01 дүгээр сарын 21 өдөр</b> Цаг: <b>11 цаг 00 минут</b>
ТӨӨЗ 2.1 а	Тендерийн эх хувиас гадна ирүүлэх хуулбар хувийн тоо: <b>“Үгүй”</b>
ТӨӨЗ 2.1 б	Захиалагч тендерүүдийг хүлээн авах хаяг нь: <b>Цахим худалдан авах ажиллагааны систем <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> хаягаар тоон гарын үсэг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (pdf)-ээр илгээнэ. Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 50,000 төгрөгийг <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> –ээр банкны меркантийн системийг ашиглан төлнө.</b> Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь Цахим худалдан авах ажиллагааны систем ( <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> ) –ийн серверийн цагаар тооцогдох тул хугацаа хоцорсон тохиолдолд тендерийн материал хүлээн авах боломжгүй. Тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө илгээсэн тендерийн материалаа буцаан засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.
ТӨӨЗ 2.2	Огноо: <b>2020 оны 01 дүгээр сарын 21 өдөр</b> Цаг: <b>11 цаг 15 минут</b>
ТӨӨЗ 2.2 б	Энэхүү тендерт гадаадын этгээд оролцох эрхгүй бөгөөд тендерийн баримт бичиг <b>Монгол хэл</b> дээр байна.
ТӨӨЗ 2.2 в	Тендерт оролцогч дараах нэмэлт материалуудыг өөрийн тендерт ирүүлнэ. Үүнд: 1. Компаний танилцуулага ирүүлнэ. 2. Жолооч нарын хэрэглээг хянахад тохирох санал болгох үйлчилгээний талаар мэдээлэл ирүүлнэ. 3. Төлбөрийн хэрэгсэл ашиглах боломжуудын талаарх мэдээлэл ирүүлнэ. /талон, карт хөнгөлөлт, урамшууллын талаарх мэдээлэл/ 4. Хот, хөдөө орон нутаг дахь шатахуун түгээх салбарын байршил оновчтой, сумдад салбартай байх /станцуудын байршлын жагсаалт ирүүлэх/ Сонгинохайрхан дүүрэг, 21 дүгээр хороо, Таширын ам, 429 дугаар хаалттай хорих анги төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт ойр байвал давуу тал болно. 5. Дизель түлш, шатахуун нь Монгол Улсын стандартын шаардлагыг хангасан байх албан мэдэгдэл ирүүлнэ.
ТӨӨЗ 2.2 г	Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад <b>тохируулахгүй тогтмол байна.</b>
ТӨӨЗ 2.2 д	Хувилбарт тендер ирүүлэхийг: <b>“Зөвшөөрөхгүй”</b>
ТӨӨЗ 2.2 е	Тендерийн валют: <b>Төгрөг байна.</b>
ТӨӨЗ 2.2 ё	Тендер нээснээс хойш <b>30</b> хоногийн туршид хүчинтэй байна.
ТӨӨЗ 3.1	Тендерт оролцогч компани гэрээг хэрэгжүүлэх чадвартайг нотлохын тулд дараах нэмэлт нотлох баримтыг тендерт ирүүлнэ. Үүнд: <b>1. Харьяа Татварын хэлтсийн тодорхойлолт /цахим/</b>

	<p><b>2.</b> Харьяа Нийгмийн даатгалын хэлтсийн тодорхойлолт <i>/шимтгэл хураамжаа төлсөн эсэх талаар/</i></p> <p><b>3.</b> Харилцагч банкны тодорхойлолт <i>/хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байна./</i></p> <p><b>4.</b> Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны <i>/төрөлжсөн архив/</i> тодорхойлолт</p> <p><b>5.</b> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолтуудыг тус тус эх хувиар ирүүлнэ.</p> <p><i>/Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө төлсөн эсэхийг тендер нээсэн өдрөөр тооцно/ Дээрх тодорхойлолтуудыг тендер зарлагдсан өдрөөс хойш авсан байна.</i></p> <p><b>6.</b> Тендерт оролцогч нь харьяа татвар, нийгмийн даатгал, харилцагч банк, шүүхийн байгуулагаас тендертэй холбоотой газруудаас лавлагаа авахад татгалзах зүйлгүй тухай мэдэгдэл ирүүлнэ</p> <p><b>7.</b> Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурах этгээдийн итгэмжлэлийг нотариатаар баталгаажуулж 2 талын этгээдийн иргэний үнэмлэхний хуулбарын хамт ирүүлнэ. Компаний захирал өөрөө өөртөө итгэмжлэл гаргаж байгаа тохиолдолд нотариатаар баталгаажуулах шаардахгүй.</p> <p><b>8.</b> Тендерийн баримт бичгийн Гэрээний ерөнхий болон Тусгай нөхцлийг зөвшөөрч байгаа талаар мэдэгдэл ирүүлнэ.</p> <p><b>9.</b> Тендерт оролцогчийн ирүүлсэн үнийн санал, тендерийн үр дүнг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдэгдэл ирүүлнэ.</p>
ТОӨЗ 7.2	Дотоодын давуу эрхийн зөрүү: <b>Тооцохгүй.</b>

**ГУРАВ: Барааны жагсаалт ба бараа нийлүүлэлтийн хуваарь**

[Захиалагч энэхүү хүснэгтийн 1-7 хүртэлх баганыг, тендерт оролцогч 8 дугаар баганыг тус тус бөглөнө ].

Багцын дугаар	Барааны нэр	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг (Ажлын талбай)	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Бараа нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Бараа нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа (Тендерт оролцогч энэ баганыг бөглөнө)
1	2	3	4	5	6	7	8
1	АИ-92	9680	л	429-р ангийн аж ахуйн хашаанд	2020 он дуустал	2020 он дуустал	
	Дизель түлш	11509.333	л				

## Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. **Барааны тодорхойлолт:** Шатахуун, Дизель түлш
2. **Стандарт:** Нийлүүлэх бараа нь дор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.
3. **Бараа хүргэх газар:** Сонгинохайрхан дүүрэг, 21 дүгээр хороо, Таширын ам, 429 дүгээр хаалттай хорих анги- төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг

1	2	3	4	5	6
Багцын дугаар	Үйлчилгээний талаарх тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	Үйлчилгээг гүйцэтгэх газар болон ажлын талбай	Үйлчилгээг гүйцэтгэж дуусгах огноо
1	АИ-92	9680	л	429-р ангийн аж ахуйн хашаанд	2020 он дуустал
	Дизель түлш	11509.333	л		



Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**  
**ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

429 ДҮГЭЭР ХААЛТТАЙ ХОРИХ АНГИ-ТӨРӨЛЖСӨН  
МЭРГЭШЛИЙН ЭМНЭЛГИЙН ДАРГА, ДЭД ХУРАНДАА Ж.ЦЭРЭНОТГОН  
дарга танаа

1. Бид, *[тендерт оролцогчийн нэр]*, *[гэрээний нэр ба дугаар]*-ыг *[тендерийн үнийг тоогоор болон үсгээр]* төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |  |       |  |
|--|-------|--|
| 1. Шалгах болон турших                             | 1.1.  | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.   |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1.  | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх                                | 3.1.  | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.  |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх     | 4.1.  | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно   |
| 5. Баталгаат засварын хугацаа                      | 5.1.  | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [тоо] жил байна.  |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах                        | 6.1.  | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.   |
| 7. Төлбөр  | 7.1.  | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан тоо] хоногийн дотор шуурхай хийнэ.   |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь                         | 8.1.  | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.   |
| 9. Алданги оногдуулах                              | 9.1.  | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.  |
| 10. Үүргээ биелүүлээгүй -гээс гэрээг цуцлах        | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.  |
| 11. Маргааныг шийдвэрлэх                           | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.   |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЕН 2.1	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: “ШШГЕГ-ЫН 429 дүгээр хаалттай хорих анги- төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт шатахуун нийлүүлэх” ШШГЕГ 429 Б19/02
ГЕН 2.1	Ажил нь: “ШШГЕГ-ЫН 429 дүгээр хаалттай хорих анги- төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт шатахуун нийлүүлэх”
ГЕН 3.1	Төслийн менежер нь: 429 ДҮГЭЭР ХААЛТТАЙ ХОРИХ АНГИ-ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЭМНЭЛГИЙН ДАРГА, ДЭД ХУРАНДАА Ж.ЦЭРЭНОТГОН
ГЕН 4.1	Ажил эхлэх өдөр <i>Гэрээ байгуулах өдрөөс эхлэнэ</i> Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр <i>Гэрээ байгуулсанаас хойш</i>
ГЕН 7.1	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш <b>3</b> хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
ГЕН 9.1	Чанарын баталгаат хугацаа <b>[1]</b> жил байна. Барьцаа хөрөнгө гэрээний үнийн дүнгийн <b>5 хувь</b> байна.
ГЕН 13.1	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн <b>0,05</b> байна.
	Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн <b>10 %</b> байна.
ГЕН 17.1	Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг <b>5 хоногийн</b> дотор гаргаж өгнө.

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

НИЙЛҮҮЛЭГЧ

БАТЛАВ.

\_\_\_\_\_ (Тамга, тэмдэг)

\_\_\_\_\_ (Тамга, тэмдэг)

\_\_\_\_\_ (Гарын үсэг)

\_\_\_\_\_ (Гарын үсэг)

\_\_\_\_\_ (Албан тушаал)

\_\_\_\_\_ (Албан тушаал)

**[Тендер  
шалгаруулалт/гэрээ  
ний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер  
шалгаруулалт/гэрээни  
й дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_\_\_ сарын \_\_\_\_ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -наас \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

5.1 Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;

5.2 Бусад шаардлагатай баримт бичиг<sup>1</sup>;

\_\_\_\_\_

- 5.3 Үнийн санал;
- 5.4 Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5 Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6 Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
- 5.7 Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

- 6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
- 7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
- 8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

---